

Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан
зардлыг нөхөн төлөх тухай
ГЭРЭЭ

20 15-ны 12 дугаар
сарын 31-ны өдөр

дугаар ХА3-2015/17/61

Улаанбаатар
хот

Ерөнхий зүйл

Нэг талаас Ашигт малтмалын газар, нөгөө талаас ашигт малтмалын ордын MV-016905 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшигч Улсын бүртгэлийн албанад бүртгэлтэй 9011071066 тоот гэрчилгээ, 2097109 тоот регистрийн дугаартай "Цогт-Онон" ХХК /цаашид аж ахуйн нэгж/ нь Ашигт малтмалын тухай хууль, Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн дугаар 81 тоот тогтооолоор батлагдсан журмыг үндэслэн улсын төсвийн хөрөнгөөр хийсэн Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг орших Уртын голын эхэн хэсгийн алтны шороон орд дээр хийгдсэн эрэл-зураглал, эрэл, урьдчилсан хайгуулын ажлын зардлуудыг улсын төсөвт эргүүлэн нөхөн төлөх нехцөл, үе шат, төлбөрийн хэмжээ, хүлээх хариуцлагыг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

**Нэгдүгээр зүйл. Ерөнхий эрэл, урьдчилсан хайгуул, нарийвчилсан хайгуул,
гидрогеологийн хайгуул, зураглалын ажлын зардлын нийт хэмжээ**

Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дахь Уртын голын эхэн хэсгийн алтны шороон орд дээр байрлах MV-016905 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд 1982-1983 онд улсын төсвөөс нийтдээ 29 963,67 төгрөгийн зардал гарсан бөгөөд ноогдох хэмжээг үндэслэн Засгийн газрын 2007 оны 81 дүгээр тогтооолоор баталсан журамд заасан аргачлалын дагуу тооцоход 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн Монгол банкны албан ёсны ханшийг /1\$=1994,36/ үндэслэн тооцоход 21 999 442,62 төгрөг буюу 11 030,83 ам.доллар болж байгааг хоёр тал хүлээн зөвшөөрөв.

Хоёрдугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх эрх, үүрэг

1. Энэхүү гэрээний нэгдүгээр зүйлд заасан зардлыг 1 жи лийн хугацаанд төлөх бөгөөд төлбөр хийх өдрийн төгрөг, америк долларын ханшаар тооцож төгрөгөөр эсвэл шууд америк доллараар төлнө.

2015 онд 3 030,83 ам.долл. / Гурван мянга гучин ам.доллар наян гурван цент /
(тоогоор) (үсгээр)

2016 онд 8 000 ам.долл. / Найман мянган ам.доллар /
(тоогоор) (үсгээр)

2. Энэхүү гэрээний хоёрдугаар зүйлийн 2.1-т дурьдсан онуудад хийхээр хуваарилсан төлбөрийг тухайн онд хавсралт 1-д заасан байдлаар Төрийн сан банкны төгрөгийн 900000712 Ашигт малтмалын газрын дансанд хийнэ.

3. Хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөр хийсний дараа уг төлбөр Ашигт малтмалын газрын дансанд орсон эсэхийг шалгаж болно.

№ХА3- 2015/17/61 гэрээ

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

Amant

4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээний 2 дугаар зүйлийн 2, 3-аар тохиролцсон үүргийн дагуу тухайн улирлын төлбөрөө улиралдаа багтаан хийгээгүй бол Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 7 дахь заалтын дагуу хугацаа хэтэрсэн хоног тутам тухайн улиралд төлбөл зохих төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алданги төлнө.

**Гуравдугаар зүйл. Ашигт малтмалын газрын
хүлээх үүрэг, эрх**

1. Энэхүү гэрээний нэгд заасан нөхөн төлбөрийн хэмжээг нөхөн төлбөр хийхээр тохиролцсон хугацаанд өөрийн санаачилгаараа өөрчлөхгүй.

2. Нөхөн төлбөр хийсэн хугацааг банкинд гүйлгээ хийсэн өдрөөр тооцно.

3. Нөхөн төлбөр хийсэн баримт бичигтэй танилцан төлбөрийн хэмжээ үнэн зөв эсэхийг магадлахдаа төлбөр хийсэн өдрийн америк доллар ба төгрөгийн Монгол банкаас зарласан албан ёсны ханшийг баримтална.

Дөрөв. Бусад зүйл


1. Ашигт малтмалын газар болон аж ахуйн нэгжийн төлөөлөгчид энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү гэрээний хоёрдугаар зүйлийн 2 дахь заалтын биелэлтийг Ашигт малтмалын газар болон аж ахуйн нэгжийн төлөөлөгчид хамтран дүгнэж акт үйлдэнэ.

3. Гэрээг гурав хувь үйлдсэн бөгөөд нэг хувийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, нэг хувийг Ашигт малтмалын газар, нэг хувийг ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч тус тус хадгална. Гэрээний хувиуд нэгэн адил хүчин төгөлдөр байна. Гэрээ нь хавсралттайгаа нийт гурван хуудаснаас бүрдэнэ.

4. Аж ахуйн нэгж нь энэхүү гэрээний заалтуудыг биелүүлээгүй тохиолдолд Ашигт малтмалын газар нь шүүхэд хандаж болох бөгөөд шүүх ажиллагаатай холбогдон гарах зардлыг аж ахуйн нэгж хариуцан төлнө.


ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:
УУЛ ҮУРХАЙН ХЭЛТСИЙН
ДАРГА С.БАТГУЛГА


ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ЭЗЭМШИЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ХХК
"ЦОГТ-ОНОН"ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Б.ОНОН

9903 6622

Ашигт малтмалын газар & “Цогт-Онон”ХХК-ийн Уртын голын эхэн хэсгийн алтны шаторбон ордын
Хайгуулын ажлын зардлыг нөхөн төлөх гэрээ



2015 онд

Улирлууд	Төлбөл зохих US\$	Төлбөр хийсэн өдрийн төгрөг ба америк долларын ханш	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1				
2				
3				
4	3 030,83			

2016 онд

Улирлууд	Төлбөл зохих US\$	Төлбөр хийсэн өдрийн төгрөг ба америк долларын ханш	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1				
2				
3	8 000			
4				

№XA3- 2015/17/.6/ гэрээ

ЭХ СУРВАЛЖ: www.iltodgerree.mn

Датум

“Цогт Онон” ХХК-ний улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөр хийх №ХАЗ-2015/61 тоот гэрээний хавсралт

2017 оны 4.-р сарын 26-и
өдөр

“Цогт Онон” ХХК-ний Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших Уртын голын эхэн хэсгийн алтны шороон ордны MY-016905A тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг. Тус компани нь №ХАЗ-2015/17/61 дугаар бүхий Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын нөхөн төлбөрийн гэрээг Ашигт малтмалын /хуучин нэрээр/ газартай 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдөр байгуулсан.

Тус компани нь эзэмшиж буй MY-016905A тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай дээрээ 2015-2016 онуудад олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд холбогдох нотлох баримт материалудыг ирүүлсэн байна. Үүнд:

1. Төв аймгийн Мэргэжлийн Хяналтын газрын 2017 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн 52 тоот олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй тухай тодорхойлолт
2. Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 02/168 тоот олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй тухай тодорхойлолт
3. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлыг БОНХАЖЯ-наас гаргасан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүгнэлтийн хүрээнд Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэсэн тухай Мон Газар Экологи ХХК-ний 2016 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 02/41,02/5 тоот албан бичиг
4. Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтсийн тодорхойлт

Дээрхи баримтуудаас үзэхэд тус компани нь 2015-2016 онуудад олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй болох нь тогтоогдож байх тул Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн “Цогт Онон” ХХК-ний №ХАЗ-2015/17/61 тоот гэрээний дагуу төлөгдөх төлбөрийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан төлөх боломжтой гэж үзэв.

Нөхөн төлбөрийг дээрхи заасан хугацаанд багтаан төлж барагдуулах, энэ хугацаанаас хэтэрвэл Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.7-д заасны дагуу алданги тооцож, эсвэл хуулийн 60.9 дэх хэсэгт заасны дагуу тусгай зөвшөөрлийг цуцлах болохыг 2 тал тохиролцов.

Гэрээний хавсралтыг баталгаажуулсан:

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГА
Ж.БАТМАГНАЙ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ЭЗЭМШИГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
Цогт-ОНОН
“ЦОГТ ОНОН” ХХК-ИЙ ЗАХИРАЛ
Б.ОНОН

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

Хавсралт №1

2018 онд

Улирлууд	Төлбөл зохих төлбөр /доллар/	Төлбөр хийсэн өдрийн төгрөг ба америк долларын ханш	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1				
2				
3	11,030.83			
4				

ЭХ СҮРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN